

ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-ийн Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэс (цаашид “ТТЛХ” гэх)-ийн биржийн гэрээний төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэ журам, түүний нэмэлт өөрчлөлтүүд, хүчин төгөлдөр мөрдөх хугацааг Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- 1.3. Энэ журмыг Биржийн ТТЛХ-ийн ажилтан болон Биржийн арилжааны зах зээлийн оролцогч (цаашид “оролцогч” гэх) нар мөрдөнө.
- 1.4. Журмын бүх хавсралт энэ журмын салшгүй хэсэг байна.

ХОЁР. КЛИРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Биржийн хэлцлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хэлцлийн төлөв өөрчлөх, хэлцлийн төлбөр тооцоог эмхтгэх зэрэг клирингийн үйл ажиллагааг ТТЛХ зохион байгуулна.
- 2.2. Бирж клирингийн үйл ажиллагааг зохион байгуулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой “Клирингийн данс”¹-ыг арилжааны банкинд нээлгэж, бүртгэлийг хөтөлнө.
- 2.3. Биржээр арилжаалсан гэрээний төлбөр тооцоо, дэнчингийн гүйлгээг хураангуйлах, нэгтгэх ажлыг ТТЛХ цахим горимд гүйцэтгэнэ.
- 2.4. “Клирингийн програм”-д хэлцлийн бүртгэл, тооцооллыг бодит цагийн горимоор гүйцэтгэнэ.
- 2.5. Арилжаанд оролцогч худалдах, худалдан авах гэрээ (цаашид “ХХАГ” гэх)-тэй холбоотой аливаа төлбөр тооцоог ТТЛХ-ээс гадна клирингийн эрхтэй байнгын гишүүнээр гүйцэтгүүлж болно. Клирингийн эрхтэй байнгын гишүүн гишүүнчлэлийн журамд заасан үйл ажиллагааг эрхэлнэ.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 3.1. Биржийн арилжааны зах зээлд оролцогчдын төлбөрийн хэрэгжилт, баталгааг хангах зорилгоор дараах эх үүсвэрийг клирингийн дансанд төвлөрүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. Дэнчин;
 - 3.1.2. Барьцаа.
- 3.2. Барьцаа болон дэнчинг энэ журмын Хавсралт.1-д заасан хуваарийн дагуу клирингийн дансанд байршуулна.
- 3.3. Арилжаанд оролцогч энэ журмын 3.10.2-т заасан шийдвэр гаргасан тохиолдолд уг гэрээний эрх, үүргээс татгалзах, бусдад шилжүүлэхтэй холбоотой гарах алдагдал, шимтгэлийг өөрөө хариуцна.
- 3.4. ТТЛХ нь дараах тохиолдолд клирингийн данснаас хөрөнгө албадан шилжүүлнэ. Үүнд:

¹Арилжаанд оролцогчдын дэнчин болон барьцаа мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх данс

- 3.4.1. Холбогдох журамд заасан хугацаанд ХХАГ-ний төлбөр төлөгдөөгүй тохиолдолд хэлцлийн нөгөө талын арилжааны шимтгэл, үнийн зөрүү²-ний алдагдлыг барагдуулах;
- 3.4.2. Биржийн шимтгэл, хураамжийг холбогдох журмын дагуу төлж, барагдуулаагүй бол.

Дэнчин

- 3.5. Арилжаанд оролцогч “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 6.1.2-т заасан дэнчинг энэ журмын гуравдугаар бүлэгт заасны дагуу клирингийн дансанд байршуулснаар арилжаанд орох эрх үүснэ.
- 3.6. Дэнчинг улирал бүрийн эхний долоо хоногт багтаан Биржийн албан ёсны цахим хуудас³-аар зарлана. Хэрэв ТТЛХ шаардлагатай гэж үзвэл дэнчингийн хэмжээг хугацаанаас өмнө өөрчилж болно. Хэрэв дэнчингийн хэмжээ хугацаанаас өмнө өөрчлөгдөх бол энэ тухай мэдээллийг ажлын 5 өдрийн өмнө биржийн албан ёсны цахим хуудсаар мэдээлнэ.
- 3.7. Дэнчингийн хэмжээг тогтоохдоо түүний төрөл болон Биржийн гэрээний тодорхойлолтод үндэслэн дараах аргачлалын аль тохирохыг ашиглана. Үүнд:
- 3.7.1. Тогтмол;
- 3.7.2. VaR;
- 3.7.3. SPAN.
- 3.8. Дэнчин нь дараах төрөлтэй байна. Үүнд:
- 3.8.1. Баталгаат дэнчин;
- 3.8.2. Анхдагч дэнчин;
- 3.8.3. Тогтворт дэнчин;
- 3.8.4. Төлбөр тооцооны дэнчин;
- 3.8.5. Хүргэлтийн дэнчин.
- 3.9. Биржийн гишүүн арилжаанд оролцохтой холбоотой гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож баталгаат дэнчинг байршуулна.
- 3.10. Арилжаанд оролцогчийн хэлцэл баталгаажуулах, хэлцлийн нөгөө талыг эрсдэлээс хамгаалах зорилгоор нийт оролцогчид анхдагч дэнчин байршуулна. Арилжаанд оролцогчийг түүний захиалгатай холбоотой аливаа эрсдэлээс хамгаалах зорилгоор анхдагч дэнчингийн тодорхой хувийг тогтворт дэнчинд тооцож, анхдагч дэнчин тогтворт дэнчингийн хэмжээнд хүрсэн тохиолдолд арилжаанд оролцогчид арилжааны програмаар дамжуулан мэдэгдэнэ. Мэдэгдэл хүлээн авсан арилжаанд оролцогч дараах үйлдлийг хийх боломжтой. Үүнд:
- 3.10.1. Дэнчингийн хэмжээг нэмэгдүүлж, Биржийн гэрээний эрх, үүргийг хадгалах;
- 3.10.2. Биржийн гэрээний эрх үүргээс татгалзах, эсвэл бусдад шилжүүлэх.
- 3.11. Хүргэлттэй гэрээний хувьд бараа хүлээлцэх, төлбөр гүйцэтгэх үеийн эрсдэлээс хамгаалах зорилгоор төлбөр тооцооны дэнчинг авах талаас, хүргэлтийн дэнчинг зарах талаас байршуулна. Спот гэрээний хувьд анхдагч дэнчинг төлбөр тооцоо болон хүргэлтийн дэнчинд тооцож болно.

Барьцаа

- 3.12. Клирингийн эрхтэй байнгын гишүүн нь харилцагчийн болон өөрийн хэлцлийн төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой аливаа эрсдэлээс хамгаалах зорилгоор клирингийн дансанд барьцаа байршуулна.

² Цуцлагдсан хэлцлийн үнэ болон дараа өдрийн жигнэсэн дундаж үнийн зөрүүг ойлгоно.

³ www.mce.mn

- 3.13. Барьцаа хөрөнгийг клирингийн эрх бүхий гишүүн Биржтэй байгуулсан гэрээний хугацаанд заавал байршуулах ба 150.0 сая төгрөгөөс багагүй дүнтэй байна. Барьцааны хэмжээг арилжаа эхлэхээс 30 минутын өмнөх үеийн үлдэгдлээр тооцно.
- 3.14. Клирингийн эрхтэй байнгын гишүүний барьцаа нь биржийн арилжааны програмд оруулсан өөрийн болон харилцагчийн анхдагч дэнчингийн хэмжээнээс багагүй байна. Хэрэв клирингийн эрхтэй байнгын гишүүний барьцаа хөрөнгө өөрийн болон харилцагчийн анхдагч дэнчингийн нийт дүнгээс бага байгаа тохиолдолд тухайн гишүүний оруулсан захиалгыг хүчингүйд тооцно.
- 3.15. Клирингийн эрхтэй байнгын гишүүний барьцаа хөрөнгө өөрийн болон харилцагчийн анхдагч дэнчингийн нийт дүнгээс бага байснаас шалтгаалан харилцагчийг хохироосон бол энэ журамд заасны дагуу хариуцлага тооцно.

ДӨРӨВ. ХЭЛЦЭЛ

- 4.1. Арилжааны програмаас тодорхойлсон, Биржийн гэрээг худалдах, худалдан авах нөхцөл таарч, тулгалт хийгдсэн захиалгуудыг хэлцэл гэж ойлгоно.
- 4.2. Биет хүргэлтгүй хэлцлийг арилжааны програм ашиглан цахим хэлбэрээр баталгаажуулж болно.
- 4.3. Биет хүргэлттэй хэлцлийн ХХАГ-г хэвлэмэл хэлбэрээр үйлдэж, захиалга оруулсан арилжаанд оролцогч, эсвэл түүний итгэмжлэл бүхий этгээд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулах ба Бирж гэрээний нэг хувийг хадгална.

Хэлцэл өөрчлөх

- 4.4. Арилжаанд оролцогч хэлцлийн нөхцөлд дараах өөрчлөлт оруулахаар ТТЛХ-т хүсэлт ирүүлж болно. Үүнд:
 - 4.4.1. Хэлцлийн төлбөр гүйцэтгэх өдрийг өөрчлөх;
 - 4.4.2. Хэлцлийн төлбөрийг хэсэгчлэн төлөх хуваарь гаргах;
 - 4.4.3. Хэлцлийн үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх.
- 4.5. Хэрэв хэлцлийн үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх бол хүсэлт гаргасан этгээд тухайн хэлцэлд харгалзах арилжааны шимтгэлийг нэмж төлнө.
- 4.6. Арилжаанд оролцогч биет хүргэлтгүй биржийн гэрээг шилжүүлэх, хүлээн авах тухай хүсэлтгээ арилжааны програмаар дамжуулан цахим хэлбэрээр гаргах ба ТТЛХ зөвшөөрсөн тохиолдолд гэрээг шилжүүлнэ.
- 4.7. ТТЛХ хэлцлийн нөхцөлд өөрчлөлт оруулахаас татгалзсан бол хүсэлт ирүүлснээс хойш нэг цагийн дотор энэ тухай арилжаанд оролцогчид мэдэгдэнэ.
- 4.8. Энэхүү журмын 4.4.1-4.4.3-т заасан хэлцлийн нөхцөл өөрчилсөнтэй холбоотой үүсэх эрсдэлийг арилжаанд оролцогч хариуцна.

Хэлцэл баталгаажуулах

- 4.9. Арилжаанд оролцогч ХХАГ-г байгуулснаар хэлцэл баталгаажуулсанд тооцно. Хэлцэлд харгалзах бараа, түүхий эдийн ХХАГ-ний дэлгэрэнгүй нөхцөл (Хавсралт.2)-ийг Биржээс баталж, Биржийн цахим хуудсанд байршуулна. Арилжаанд оролцогч ХХАГ-г байгуулахдаа хялбаршуулсан товч хэлбэр (Хавсралт.3)-ээр үйлдэж болно.
- 4.10. Арилжаанд оролцогч хэлцлийн жагсаалтыг үндэслэн ХХАГ-г дараа өдрийн арилжаа эхлэхээс өмнө байгуулж, ТТЛХ-т нэг хувийг ирүүлнэ. Бирж зөвшөөрсөн тохиолдолд гэрээг цахим хэлбэрээр ирүүлж болно.
- 4.11. Арилжаанд оролцогч ХХАГ-ний товч хэлбэрт гарын үсэг зурснаар гэрээний дэлгэрэнгүй хэлбэрт заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Гэрээний талууд гарын

үсгээ тус бүрийн хувь дээр зурж гэрээнд хавсаргаж болно. Энэ тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр гэж үзнэ.

- 4.12. Биржийн гэрээний тодорхойлолтод заасан арилжааны сүүлийн өдөр ХХАГ-г баталгаажуулж, хүргэлтийн болон төлбөр тооцооны дэнчинг байршуулна. Хэрэв хүргэлтийн болон төлбөр тооцооны дэнчинг хугацаандаа байршуулаагүй бол гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцно.

Хэлцэл цуцлах

- 4.13. Дараах тохиолдолд хэлцэл цуцалж болно. Үүнд:
- 4.13.1. Талууд харилцан зөвшөөрсөн;
 - 4.13.2. Шүүх, хяналтын байгууллагаар хууль зөрчсөн хэлцэл хийсэн нь тогтоогдсон;
 - 4.13.3. Арилжаанд оролцогчийн болгоомжгүй үйлдлээс шалтгаалан хэлцэл хийгдсэн нь тогтоогдсон;
 - 4.13.4. Биржийн мэргэжилтний алдаанаас шалтгаалан хэлцэл хийгдсэн болох нь тогтоогдсон;
 - 4.13.5. Хэлцлийн нэг талын хүсэлт гаргасан.
- 4.14. Хэрэв зарах талын бараа барааны тодорхойлолт заасан шаардлагад нийцээгүйгээс болж хэлцэл цуцлагдсан бол зарах тал, бусад үндэслэлээр энэ журмын 4.13.5 заасны дагуу хэлцэл цуцлах бол хүсэлт гаргасан этгээд тухайн хэлцлийн 2 талын холбогдох шимтгэлийг төлнө.
- 4.15. Хэрэв хэлцэл цуцлагдсан бол ТТЛХ энэ тухай баримтыг үйлдэж хадгална. Арилжаанд оролцогчийн хэлцэл цуцлагдсан бол энэ нь арилжааны шимтгэлийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 5.1. ТТЛХ дараах төрлийн төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Үүнд:
- 5.1.1. Дэнчин, барьцаа хөрөнгийн гүйлгээ;
 - 5.1.2. М2М;
 - 5.1.3. ХХАГ-ний төлбөр;
 - 5.1.4. Шимтгэлийн гүйлгээ;
 - 5.1.5. Бусад.
- 5.2. Төлбөр тооцоо гүйцэтгэх үнэ нь захиалга биелсэн хэлцлийн үнэ байна. Биет хүргэлттэй фьючерс гэрээний төлбөр тооцоо гүйцэтгэх үнэ нь арилжаа хийгдэх сүүлийн өдрийн хаалтын үнэ байна.
- 5.3. Төлбөр тооцоо гүйцэтгэх үнэ нь арилжаанд оролцогчдын хувьд заавал дагаж мөрдөх, Биржийн гэрээний төлбөр тооцоонд ашиглагдах үнэ байна.

Дэнчин, барьцаа хөрөнгийн гүйлгээ

- 5.4. Арилжаанд оролцогч дэнчин, барьцаа хөрөнгийг Хавсралт.5-д заасны дагуу Биржийн клирингийн дансанд байршуулна.
- 5.5. Арилжаанд оролцогч Биржийн гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн, Биржид өр төлбөргүй бол дэнчин, барьцаа хөрөнгийг буцаан авах эрх үүснэ. ТТЛХ нь Хавсралт.6-д заасан маягтын дагуу гаргасан биржийн гишүүний хүсэлтийг үндэслэн дэнчин, барьцаа хөрөнгийг буцаан шилжүүлнэ.

М2М

- 5.6. ТТЛХ нь фьючерс гэрээ эзэмшигчийн ашиг, алдагдлыг бодит цагийн горимоор бүртгэх бөгөөд өдрийн эцэст буюу 16:00 цагаас хойш арилжаанд оролцогчийн анхдагч дэнчинг ашиг, алдагдлын зөрүүгээр нэмэгдүүлэх эсвэл бууруулах гүйлгээг хийнэ.

ХХАГ-ний төлбөр

- 5.7. ТТЛХ арилжаанд оролцогчийн гэрээний дүнг энэ журмын Хавсралт.4-т заасан маягтын дагуу худалдан авах талаас нэхэмжилнэ.
- 5.8. Худалдах, худалдах авах гэрээний авах тал энэ журмын нэхэмжлэхэд заасан гэрээний дүнг бараа хүлээлцэхээс өмнө төлбөр тооцооны дансанд байршуулсан байна.
- 5.9. ТТЛХ хэлцлийн зарах талын ирүүлсэн бараа хүлээлцсэн баримт (Хавсралт.7)-д тусгасан дүн (“төлбөр тооцооны дүн” гэх)-г худалдан авагч талын гэрээний төлбөр Биржийн төлбөр тооцооны дансанд орсон өдөр гэрээнд заасан данс руу шилжүүлнэ.
- 5.10. Бараа хүлээлцсэн баримтад заасан тоо, хэмжээ нь гэрээнд зааснаас Биржийн гэрээний тодорхойлолтод зөвшөөрсөн хэмжээгээр өөрчлөгдөж болно. Хэрэв төлбөр тооцооны дүн гэрээний дүнгээс их бол уг зөрүүг авах талын төлбөрийн дэнчингээс суутгаж, энэ журамд заасны дагуу зарах талын дансанд шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд зөрүү дүнг авах талын данс руу буцааж шилүүлнэ.

Шимтгэлийн гүйлгээ

- 5.11. ТТЛХ байнгын гишүүний хүсэлт, эсвэл гишүүний гэрээнд заасны дагуу түүний зуучлалын шимтгэлийг харилцагчдаас нэхэмжилж (Хавсралт.8), төлбөр тооцооны дансанд төвлөрүүлж болно.
- 5.12. ТТЛХ байнгын гишүүний зуучлалын шимтгэлийг долоо хоног бүрээр хуримтлуулж, тухайн долоо хоногт харгалзах шимтгэлийн нийт дүнг уг долоо хоногийн сүүлийн ажлын өдрийн 17:00 цагаас өмнө түүний дансанд шилжүүлнэ.

Бусад

- 5.13. Биржийн дэнчингийн болон төлбөр тооцооны дансанд андуурсан гүйлгээ хийгдсэн бол тухайн этгээдийн албан бичгээр Биржид ирүүлсэн хүсэлтийг үндэслэн шилжүүлнэ.

Төлбөр тооцоонд хориглох зүйлс

- 5.14. Албан ёсны тэмдэглэлт болон нийтээр амрах өдрүүд ТТЛХ-ийн төлбөр тооцоо гүйцэтгэх өдөрт хамаарахгүй.
- 5.15. Спот гэрээний дэнчинг төлбөр тооцоонд ашиглахгүй.
- 5.16. Төлбөр тооцоог аливаа бичиг баримтын хуулбар хувийг үндэслэн хийхийг хориглоно.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Арилжаанд оролцогч энэ журмыг зөрчсөн болон Биржээр арилжсан гэрээний үүргээ биелүүлээгүй бол “Хяналтын журам” болон бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хариуцлага хүлээнэ.
- 6.2. Төлбөр тооцоо гүйцэтгэх үед аливаа зөрчил илэрвэл ТТЛХ зөрчил гаргасан этгээдэд сануулах, арилжааны дансыг битүүмжлэх, баталгаат дэнчингээс суутгах хүртэл арга хэмжээ авч болно. Шаардлагатай тохиолдолд зөрчлийн мэдээллийг Захиргаа дотоод аудитын хэлтэст шилжүүлж холбогдох журмын дагуу шийдвэрлүүлнэ.
- 6.3. Арилжаанд оролцогч энэ журам болон төлбөр тооцоотой холбоотой аливаа эрх зүйн баримт бичгийг мэдээгүй, эсвэл ойлгоогүй нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.4. Биржийн гишүүн оролцогч нь өөрийн болон харилцагчийнхаа нэрийн өмнөөс Биржээр арилжаалсан гэрээний биелэлтийг бүрэн хариуцна.
- 6.5. Арилжааны банкны үйл ажиллагааны буруугаас болж аливаа зөрчил илэрсэн бол Бирж хариуцлага хүлээхгүй.

Дэнчин байршуулах цагийн хуваарь

№	Дэнчингийн төрөл	Цагийн хуваарь
1	Баталгаат дэнчин	10:00 цагаас өмнө
2	Анхдагч дэнчин	10:00 цагаас өмнө
3	Хүргэлтийн дэнчин	Мэдэгдэл хүлээн авсан өдрийн 15 цагаас өмнө
4	Төлбөр тооцооны дэнчин	Мэдэгдэл хүлээн авсан өдрийн 15 цагаас өмнө

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

(Дэлгэрэнгүй хэлбэр)

Энэхүү Биржээр арилжаалсан гэрээний бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах гэрээ (цаашид Гэрээ гэх)-г

Нэг талаас тулгалт хийгдсэн зарах захиалга оруулсан арилжаанд оролцогч (цаашид “Худалдагч” гэх),

Нөгөө талаас Бирж дээр тулгалт хийгдсэн авах захиалга оруулсан арилжаанд оролцогч (цаашид “Худалдан авагч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх)

Монгол Улсын Иргэний хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 7.1 дэх заалт, Хөдөө аж ахуйн биржээр тулгалт хийгдсэн хэлцлийг тус тус үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

Гэрээнд заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

- **Арилжаанд оролцогч** гэж Биржтэй гишүүнчлэлийн гэрээ бүхий брокерын компани болон тэдгээртэй зуучлалын гэрээ бүхий харилцагчийг хамтад нь ойлгоно.
- **Банк** гэж Биржтэй хамтран ажиллах гэрээ бүхий арилжааны банкныг,
- **Бирж** гэж Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийг,
- **Гэрээ хаагдах өдөр** гэж Гэрээний 4.1-д заасан бараа, түүхий эд хүлээлцэх сүүлийн өдрийг,
- **Бараа, түүхий эд** гэж Талуудын өгсөн захиалгын үндсэн дээр Биржээр арилжаалсан Гэрээний 2.1-г тодорхойлсон Худалдагчийн Худалдан авагчид нийлүүлбэл зохих нийт бараа, түүхий эдийг
- **Зуучлалын гэрээ** гэж Биржийн байнгын гишүүн болон түүний харилцагч хоёрын хооронд байгуулагдсан данс нээх, арилжаанд зуучлах тухай харилцааг зохицуулсан гэрээг,
- **Хүлээлцэх акт** гэж Худалдагч бараа, түүхий эдийг Худалдан авагчид нийлүүлснийг нотлох баримт бичгийг,

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Талууд Биржийн арилжаанд зуучлалын гэрээ бүхий брокероор дамжуулан оролцож, худалдах, худалдан авах бараа, түүхий эдийн төрөл, жин, үнийг тогтоосон болно.
- 1.2. Гэрээний 1.1-г заасны дагуу Биржээр арилжаалсан бараа, түүхий эдийг Худалдагч нь Гэрээнд заасан газар, хугацаанд Худалдан авагчид нийлүүлэх, Худалдан авагч нь бараа, түүхий эдийг зохих ёсоор хүлээн авч, төлбөрийг Худалдагчид төлөхтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг Төлбөр тооцоо, ложистикийн журмаар, бусад нарийвчилсан харилцааг энэ Гэрээгээр зохицуулна.
- 1.3. Дараах баримт бичгүүд нь энэ Гэрээний салшгүй нэг хэсэг байна.
 - 1.3.1. Хөдөө аж ахуйн биржийн гэрээний тодорхойлолт (цаашид “Биржийн гэрээний тодорхойлолт” гэнэ),
 - 1.3.2. Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн тодорхойлолт (цаашид “Барааны тодорхойлолт” гэнэ),
 - 1.3.3. Хөдөө аж ахуйн биржийн төлбөр тооцооны журам (цаашид “Төлбөр тооцооны журам” гэнэ),
 - 1.3.4. Энэ гэрээнд харгалзах захиалгын мэдээлэл, тэдгээрийн тулгалт хийгдсэн хэлцэл
 - 1.3.5. Биржийн арилжаатай холбоотой Бирж болон төрийн эрх бүхий байгууллагаас баталсан бусад дүрэм, журмууд,
 - 1.3.6. Талуудын бусдад олгосон итгэмжлэл.

Хоёр. Бараа, түүхий эд

- 2.1. Худалдагч нь Худалдан авагчид Барааны тодорхойлолтын хоёрдугаар бүлэгт заасан техникийн шаардлагад нийцсэн бараа, түүхий эдийг худалдана.
- 2.2. Барааны тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангаагүй бараа, түүхий эдийг Талууд тохиролцон хүлээлцэж болно. Тохиролцон хүлээлцэхэд жинг хорогдуулах байдлаар тооцно. Талууд тохиролцоогүй бол Гэрээний 2.1-т заасан шаардлагыг хангаагүй бараа, түүхий эдийг худалдан авагч хүлээн авахаас татгалзаж болно.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1. Гэрээгээр нийлүүлэх бараа, түүхий эдийн үнийг Төлбөр тооцоо ложистикийн журмын 5.2-т заасны дагуу тооцно.
- 3.2. Гэрээ хаагдах үеийн бараа, түүхий эдийн зах зээлийн ханшны өөрчлөлтөөс үл хамааран Гэрээний 3.1-т заасан үнэ өөрчлөгдөхгүй тогтвортой байна. Талууд энэхүү Гэрээнд заасан үнийг өөрчлөхийг хориглоно.
- 3.3. Гэрээ хаагдахаас өмнө Талуудын хүргэлтийн болон төлбөр тооцооны дэнчинг холбогдох дансанд байршуулах, Гэрээ хаагдаж Хүлээлцэх акт үйлдэгдсэний дараа бараа, түүхий эдийн төлбөрийг Худалдан авагчаас нэхэмжлэх, худалдагчид шилжүүлэхтэй холбоотой асуудлыг Төлбөр тооцоо ложистикийн журмаар зохицуулна.
- 3.4. Худалдан авагч төлбөрийг хугацаандаа төлөөгүй бол Гэрээний 10 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

Дөрөв. Бараа, түүхий эд хүлээлцэх хугацаа, газар

- 4.1. Талууд бараа, түүхий эдийг Биржийн гэрээний тодорхойлолтод заасан газар, хугацаанд хүлээлцэх ба уг хугацааг хэтрүүлэхийг хориглоно.
- 4.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээний 4.1-т заасан хугацаанаас өмнө бараа, түүхий эдийг хүлээлцэж болно. Энэ тохиолдолд хугацаанаас өмнө бараа, түүхий эд хүлээлцэх тухай мэдэгдлийг Биржид хүргүүлнэ.
- 4.3. Гэрээний 4.1-т заасан бараа, түүхий эд хүлээлцэх газрыг Талууд өөрчлөхөд Гэрээний 4.2-т заасан журам адил үйлчилнэ.
- 4.4. Гэрээ хаагдахын өмнөх ажлын 3 өдрийн дотор Талууд бараа, түүхий эд хүлээлцэх хугацаа, газрыг өөрчлөхийг хориглоно.

Тав. Бараа, түүхий эдийг хүлээлцэх

- 5.1. Талууд бараа, түүхий эдийг хүлээлцэхдээ энэ Гэрээнд зааснаас гадна барааны тодорхойлолтод заасан ерөнхий журмыг баримтална.
- 5.2. Худалдагч Гэрээний 4.1-т заасан газар, хугацаанд бараа, түүхий эдийг өөрийн зардлаар тээвэрлэж, нийлүүлнэ.
- 5.3. Бараа, түүхий эд хүлээлцэхэд дараах этгээд, эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч байлцана. Үүнд:
 - 5.3.1. Худалдагч тал
 - 5.3.2. Худалдагч талын брокер,
 - 5.3.3. Худалдан авагч тал,
 - 5.3.4. Худалдан авагч талын брокер.
- 5.4. Бараа, түүхий эдийг хүлээлцэхэд дараах бичиг баримтыг Худалдагч тал бүрдүүлнэ. Үүнд:
 - 5.4.1. Бараа, түүхий эдийн гарал үүслийн бичиг,
 - 5.4.2. Лабораторийн дүгнэлт,
 - 5.4.3. Малын эрүүл мэндийн бичиг (зөвхөн малд хамаарна).
- 5.5. Бараа, түүхий эд хүлээлцэх үед бараа, түүхий эдийн ангилал, чанар, эрүүл ахуйн талаар Талуудын хооронд үүссэн маргааныг хөндлөнгийн лабораторийн дүгнэлт (малд хамаарахгүй), Мал эмнэлэг үржлийн газрын мэргэжилтний дүгнэлт (зөвхөн малд хамаарна)-ээр шийдвэрлэнэ.

- 5.6. Бараа, түүхий эдийг Стандартчилал, хэмжилзүйн газрын баталгаажуулсан жингээр жинлэн хүлээлцэнэ. Жин, түүний бүрэн бүтэн байдлыг Худалдан авагч тал хариуцна.
- 5.7. Гэрээнд заасан болон нийлүүлсэн бараа, түүхий эдийн жингийн зөрүүний асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 5.7.1. Жинлэсэн бараа, түүхий эдийн нийт хэмжээ Гэрээний тодорхойлолтод заасан зөвшөөрөгдөх хэмжээнд хэлбэлзэж байвал Худалдан авагч бараа, түүхий эдийг бүхэлд нь хүлээн авах үүрэг хүлээнэ.
- 5.7.2. Жинлэсэн бараа, түүхий эдийн нийт хэмжээ Гэрээний тодорхойлолтод заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гарсан тохиолдолд хэтэрсэн жинд ногдох бараа, түүхий эдийг Худалдан авагч хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 5.7.3. Жинлэсэн бараа, түүхий эдийн нийт хэмжээ Гэрээний тодорхойлолтод заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс дутсан тохиолдолд Худалдан авагч тухайн бараа, түүхий эдийг бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 5.8. Бараа, түүхий эдийг хүлээлцсэн Талууд Бараа хүлээлцсэн баримтыг үйлдэнэ. Хүлээлцсэн баримт үйлдэхэд дараах шаардлагыг тавина. Үүнд:
- 5.8.1. Гэрээний 5.3-д заасан этгээдүүд гарын үсэг зурах, тамга тэмдгээр баталгаажуулах,
- 5.8.2. Лабораторийн дүгнэлт гаргуулсан бол түүнийг хавсаргах,
- 5.9. Талууд Бараа хүлээлцсэн баримт үйлдсэнээр хүлээлцэх ажиллагааг дууссанд тооцно.
- 5.10. Худалдагч талын брокер Бараа хүлээлцсэн баримтыг ажлын 1 өдрийн дотор Биржид хүргэх үүрэг хүлээнэ.
- 5.11. Бараа, түүхий эд хүлээлцэхтэй холбоотой зардал, эрсдэлийг Талууд дараах байдлаар хариуцна. Үүнд:
- 5.11.1. Хүлээлцэх актад гарын үсэг зурах хүртэл худалдагч тал,
- 5.11.2. Хүлээлцэх акт зурснаас хойш худалдан авагч тал.
- 5.12. Талууд энэ зүйлд заасан малыг хүлээлцэх журмыг зөрчсөн тохиолдолд Гэрээний 10 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

Зургаа. Талуудын үүрэг

- 6.1. Худалдагч тал хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүрэгтэй. Үүнд:
- 6.1.1. Бараа, түүхий эдийг Гэрээнд заасан газар, хугацаанд Гэрээнд заасан нөхцөлөөр Худалдан авагчид нийлүүлэх,
- 6.1.2. Монгол Улсын холбогдох стандарт болон Барааны тодорхойлолтод нийцсэн бараа, түүхий эдийг Худалдан авагчид нийлүүлэх,
- 6.1.3. Хүлээлцэх акт үйлдэх хүртэлх холбогдох зардал, эрдслийг хариуцах,
- 6.1.4. Биржийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой Биржээс тогтоосон шимтгэл, хураамжийг төлөх,
- 6.1.5. Бараа, түүхий эдийг нийлүүлэхтэй холбоотой бичиг баримтыг Худалдан авагчид гаргаж өгөх,
- 6.1.6. Бараа, түүхий эдийг Гэрээнд заасан газар, хугацаанд Гэрээнд заасан нөхцөлөөр Худалдан авагчид нийлүүлээгүй буюу Гэрээг зөрчсөн тохиолдолд түүнээс үүсэх хохирлыг хариуцах, Гэрээнд заасан хариуцлагыг хүлээх.
- 6.2. Худалдан авагч хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүрэгтэй. Үүнд:
- 6.2.1. Бараа, түүхий эдийг Гэрээнд заасан газар, хугацаа, нөхцөлөөр хүлээн авах,
- 6.2.2. Төлбөр тооцоо, ложистикийн журамд заасан нөхцөл болон Биржээс тогтоосон шаардлагын дагуу бараа, түүхий эдийн төлбөрийг төлөх,
- 6.2.3. Биржийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой Биржээс тогтоосон шимтгэл, хураамжийг төлөх,
- 6.2.4. Бараа, түүхий эдийг хүлээлцэх акт үйлдсэний дараа үүсч болох аливаа эрсдэлийг хариуцах,
- 6.2.5. Бараа, түүхий эдийг хугацаандаа хүлээж аваагүй буюу Гэрээг зөрчсөн тохиолдолд түүнээс үүсэх хохирлыг хариуцах, Гэрээнд заасан хариуцлагыг хүлээх.

Долоо. Амлалт, баталгаа

- 9.1. Худалдагч дараах амлалт, баталгааг гаргаж байна. Үүнд:
- 9.1.1. Худалдагчийг төлөөлж гэрээ байгуулж буй этгээд нь энэхүү Гэрээг байгуулах бүрэн эрхтэй этгээд мөн.
 - 9.1.2. Гэрээ байгуулахаас өмнө Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам, Төлбөр тооцоо, ложистикийн журам, Барааны тодорхойлолт зэрэг Биржээс баталсан дүрэм журмуудтай танилцаж, ойлгосон.
 - 9.1.3. Гэрээний дагуу нийлүүлэх бараа, түүхий эд нь худалдагчийн өөрийн өмчлөлийн бараа, түүхий эд мөн бөгөөд түүнийг худалдах нь гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй.
 - 9.1.4. Нийлүүлэх бараа, түүхий эд нь Барааны тодорхойлолтод нийцсэн.
 - 9.1.5. Гэрээ хаагдах үеийн бараа, түүхий эдийн зах зээлийн үнэ, байгаль цаг уурын нөхцөл (давагдашгүй хүчин зүйлээс бусад)-ийг үл харгалзан бараа, түүхий эдийг Гэрээнд заасан газар, хугацаанд Худалдан авагчид нийлүүлэх боломжтой.
 - 9.1.6. Бараа, түүхий эдийг нийлүүлэх үед Талуудын хооронд үүссэн саналын зөрүүг шийдвэрлэсэн хөндлөнгийн лаборатори (эсвэл МЭҮТ-ийн мэргэжилтэн)-ийн дүгнэлт шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.
 - 9.1.7. Гэрээг зөрчсөн тохиолдолд Гэрээнд заасан хариуцлагыг хүлээхэд татгалзах зүйлгүй болно.
- 9.2. Худалдан авагч дараах амлалт, баталгааг гаргаж байна. Үүнд:
- 9.2.1. Худалдан авагчийг төлөөлж гэрээ байгуулж буй этгээд нь энэхүү Гэрээг байгуулах бүрэн эрхтэй этгээд мөн .
 - 9.2.2. Гэрээ байгуулахаас өмнө Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам, Төлбөр тооцоо, ложистикийн журам, Барааны тодорхойлолт зэрэг Биржээс баталсан дүрэм журмуудтай танилцаж, ойлгосон.
 - 9.2.3. Гэрээ байгуулах үеийн бараа, түүхий эдийн зах зээлийн үнэ ханшийг үл харгалзан бараа, түүхий эдийг Гэрээнд заасан нөхцөлөөр худалдан авах боломжтой.
 - 9.2.4. Бараа, түүхий эдийг нийлүүлэх үед Талуудын хооронд үүссэн саналын зөрүүг шийдвэрлэсэн хөндлөнгийн лаборатори (эсвэл МЭҮТ-ийн мэргэжилтэн)-ийн дүгнэлт шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.
 - 9.2.5. Бараа, түүхий эдийг худалдан авах санхүүгийн боломжтой бөгөөд Гэрээний төлбөрийг Төлбөр тооцоо, ложистикийн журамд заасан хугацаанд төлөх боломжтой.
 - 9.2.6. Гэрээг зөрчсөн тохиолдолд Худалдагч талд алданги төлөх болон Гэрээнд заасан бусад хариуцлагыг хүлээхэд татгалзах зүйлгүй болно.
- 9.3. Талуудын гаргасан амлалт, баталгааны аль нэг нь худлаа болох нь хожим илэрвэл, эсхүл Талууд амлалт, баталгаагаа зөрчсөн тохиолдолд буруутай этгээд Гэрээний 10 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

Найм. Хориглох зүйлс

- 8.1. Талуудад дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 8.1.1. Худалдагч бараа, түүхий эдийг нийлүүлэхээс татгалзах, хугацаандаа нийлүүлэхгүй байх,
 - 8.1.2. Худалдан авагч бараа, түүхий эдийг худалдан авахаас татгалзах, бараа, түүхий эдийг зохих ёсоор хүлээж авахгүй байх,
 - 8.1.3. Худалдан авагч бараа, түүхий эдийг нийлүүлэхэд өөрөө буюу өөрийн төлөөлөгчийг ирүүлэхгүй байх,
 - 8.1.4. Худалдан авагч гэрээний төлбөрийг Гэрээнд заасан журмын дагуу төлөхгүй байх.
- 8.2. Гэрээний 8.1-т тодорхой зүйлсийг хориглохоор заасан нь тус зүйлд заагаагүй Гэрээг зөрчихөд чиглэсэн бусад үйлдлийг хийхийг зөвшөөрсөн утгыг илэрхийлэхгүй болно.
- 8.3. Гэрээний 8.1 заалтыг зөрчсөн тал Гэрээний 10 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

Ес. Гэрээний зөрчил ба хариуцлага

- 9.1. Талууд Биржээс баталсан дүрэм, журмууд болон Гэрээний аль нэг заалтыг зөрчсөн тохиолдлыг гэрээний зөрчил гэж үзнэ.
- 9.2. Аль нэг тал Гэрээний зөрчил гаргасны улмаас нөгөө талд, эсхүл гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол тухайн хохирлыг зөрчил гаргасан тал арилгах үүрэгтэй.
- 9.3. Худалдагч тал Гэрээний зөрчил гаргасан тохиолдолд Гэрээний 9.2-т зааснаар хохирлыг арилгасан эсэхээс үл хамааран дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:
 - 9.3.1. Худалдагч талын брокерын Биржийн арилжаанд оролцох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасуулах саналыг Биржид хүргүүлэх,
 - 9.3.2. Худалдагчийн брокерын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх,
 - 9.3.3. Биржээс баталсан холбогдох журамд заасан бусад хариуцлага.
- 9.4. Худалдан авагч нь Гэрээний зөрчил гаргасан тохиолдолд Гэрээний 9.2-т зааснаар хохирлыг арилгасан эсэхээс үл хамааран дараах хариуцлагыг хүлээнэ.
 - 9.4.1. Малын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг төлөх.
 - 9.4.2. Худалдан авагч талын брокерын Биржийн арилжаанд оролцох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах саналыг Биржид хүргүүлэх,
 - 9.4.3. Худалдан авагчийн брокерын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх,
 - 9.4.4. Худалдан авагчийн гаргасан зөрчлийн талаар Биржийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх,
 - 9.4.5. Биржээс баталсан холбогдох журамд заасан бусад хариуцлага.
- 9.5. Гэрээний зөрчил гаргасны улмаас бусдад учирсан хохирол, алданги зэргийг буруутай талын дэнчин (Гэрээний 3.4-т заасан)-гээс тэргүүн ээлжинд барагдуулах ба дэнчин нь хохирол, алдангийг барагдуулахад хүрэлцэхгүй тохиолдолд өөрийн бусад хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 9.6. Гэрээний зөрчил гаргасан тал зөрчлийн улмаас үүссэн хохирлыг үл маргах журмаар барагдуулсан нь түүнийг Гэрээний 9.3, 9.4-т заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Арав. Гэрээ цуцлах

- 10.1. Талууд дараах үндэслэлээр Гэрээг цуцалж болно.
 - 10.1.1. Нөгөө тал Гэрээний 8.1-т заасан хориглох зүйлсийг зөрчсөн,
 - 10.1.2. Аль нэг тал, эсвэл түүний брокерын Биржтэй холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийг эрх бүхий байгууллага хүчингүй болгосон,
 - 10.1.3. Гэрээний 11.5-д заасан үндэслэлээр Худалдагч тал бараа, түүхий эдийг нийлүүлэх боломжгүй болсон,
- 10.2. Талууд гэрээний 10.1-т зааснаас бусад үндэслэлээр харилцан тохиролцож гэрээг цуцалж болно. Талууд харилцан тохиролцож гэрээг цуцалсан тохиолдолд ажлын 1 өдрийн дотор Биржид мэдэгдэнэ.
- 10.3. Аль нэг тал Гэрээний 10.1-т заасан үндэслэлээр Гэрээг цуцлах шаардлагатай үзвэл нөгөө талдаа болон Гэрээний 12.2-т заасан арбитра нэн даруй мэдэгдэж, Гэрээ цуцлах саналыг гаргана.
- 10.4. Арбитр Гэрээний 10.3-т заасан саналыг хүлээн авч Гэрээг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 10.5. Гэрээний 10.1.1, 10.1.2-т заасан үндэслэлээр Гэрээ цуцлагдсан тохиолдолд буруутай тал Гэрээний 9 дүгээр зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 10.6. Гэрээг энэ зүйлд зааснаас бусад үндэслэл, журмаар цуцлахыг хориглоно.

Арван нэг. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

- 11.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас аль нэг тал Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол түүнийг Гэрээг зөрчсөн гэж үзэхгүй.
- 11.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсэд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:
 - 11.2.1. Газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт зэрэг Талуудын хүсэл зоригоос үл хамааран үүсч болох байгалийн хүчин зүйл,
 - 11.2.2. Хуульд нийцсэн төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр,
 - 11.2.3. Нийтийн хамарсан ажил хаялт, үймээн самуун, халдлага, эсэргүүцлийн хөдөлгөөн.
- 11.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон гэж үзсэн тал энэ тухайгаа нөгөө талдаа болон Гэрээний 12.2-т заасан арбитра нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 11.4. Тухайн нөхцөл байдал нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл мөн эсэхийг холбогдох баримтад тулгуурлан арбитра шийдвэрлэнэ.
- 11.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл аль ч тал гэрээг цуцлах эрхтэй.

Арван хоёр. Маргаан шийдвэрлэх

- 12.1. Талуудын хооронд үүссэн маргааныг Талууд өөрсдөө болон брокероор дамжуулан эвийн журмаар шийдвэрлэхийг хичээх үүрэгтэй.
- 12.2. Талууд маргааныг Гэрээний 12.1-д заасан аргаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргааныг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 15.2, Арбитрийн тухай хуулийн 4.1.2-д заасны дагуу Биржийн арилжаанд оролцогчдын дэргэд байгуулагдах Түр арбитраар, түүний тогтоосон дүрмийн дагуу Монгол улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 12.3. Гэрээний 12.2-т заасан арбитрайн шийдвэр эцсийнх байна

Арван гурав. Бусад

- 13.1. Гэрээг монгол хэл дээр, бичгээр хоёр хувь үйлдсэн бөгөөд Талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.
- 13.2. Гэрээ нь Талууд, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдүүд “Худалдах, худалдан авах гэрээ”-ний товч хэлбэрт гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 13.3. Гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бусад тооцогдсон нь бусад заалтын хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.
- 13.4. Гэрээний хавсралт, аливаа нэмэлт өөрчлөлтүүд нь Гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 13.5. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээний 13.1-т заасан шаардлагад нийцүүлэн Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
(Товч хэлбэр)

Биржээр арилжаалсан _____ (*spot, форвард, фьючерс*) гэрээний бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г 201_ оны __ сарын __ өдөр,

Нэг талаас _____ арилжааны дансны дугаартай, _____ тоот регистрийн дугаартай _____ овогтой _____ (цаашид “Худалдагч” гэх)-ийг төлөөлж _____ арилжааны дансны дугаартай, _____ тоот регистрийн дугаартай _____ ХК/ХХК (цаашид “Худалдагч талын брокер” гэх)-ийн брокер _____ овогтой _____,

Нөгөө талаас _____ арилжааны дансны дугаартай, _____ тоот регистрийн дугаартай _____ овогтой _____ (цаашид “Худалдан авагч” гэх)-ийг төлөөлж _____ арилжааны дансны дугаартай, _____ тоот регистрийн дугаартай _____ ХК/ХХК (цаашид “Худалдагч талын брокер” гэх)-ийн брокер _____ овогтой _____ нар (хамтад нь “Талууд” гэх)

Монгол Улсын Иргэний хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн (7.2, 7.3, 7.4) дахь заалтууд, Хөдөө аж ахуйн биржийн 201_ оны __ сарын __ өдрийн арилжааны _____ дугаартай хэлцлийг тус тус үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Худалдагч _____ богц, _____ код бүхий бараа, түүхий эдийг богц бүрийг _____ төгрөгөөр Худалдан авагчид “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дэлгэрэнгүй хэлбэрийн 2-р бүлэгт заасны дагуу нийлүүлж, худалдан авагч _____ (_____) төгрөгийг “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дэлгэрэнгүй хэлбэрийн 3-р бүлэгт заасны дагуу шилжүүлэх үүргийг тус тус хүлээнэ.
2. Худалдагч гэрээний төлбөрийг _____ банкны _____ нэртэй, _____ дансаар хүлээн авна.
3. Талууд _____ газар 201_ оны __ сарын __-ны өдрийн _____ цагаас хүлээлцэх ажлыг эхлүүлнэ.
4. Бараа, түүхий эдийг хүлээлцэхэд “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дэлгэрэнгүй хэлбэрийн _____ (5.3.1-5.3.4-т зааснаас сонгох)-д заасан этгээдүүд байлцаж, “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дэлгэрэнгүй хэлбэрийн 5.8-д заасан “бараа хүлээлцсэн баримт” үйлдэж, Биржид хүргүүлнэ.
5. “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дэлгэрэнгүй хэлбэр нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна. “Худалдах, худалдан авах гэрээ”-ний дэлгэрэнгүй хэлбэр болон товч хэлбэр нь ижил тэнцүү үйлчилнэ.
6. Энэхүү гэрээний мэдээллийг үнэ зөвийг баталж, гэрээнд талуудаас гадна тэдгээрийн брокер тамга, тэмдэгээр баталгаажуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Худалдагч

Худалдан авагч

/гарын үсэг/

Утас: _____

/гарын үсэг/

Утас: _____

/Брокерын тамга/

/Брокерын тамга/



ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭХ

Огноо:

Хэнд:	Арилжаанд оролцогч дансны дугаар:	
Нэхэмжлэх дүн, тоогоор:	Нэхэмжлэх дүн, бичгээр:	
Гэрээнд заасан хэлцлийн дугаар:	Хэлцэл хийгдсэн огноо:	Төлбөр хийгдэх сүүлийн хугацаа:
Төлбөр хүлээн авах данс:	ХААН Банк 5099 04 0055 Төрийн Банк 1060 0002 6114	
<p>НЭХЭМЖЛЭГЧ: ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ТӨЛБӨР ТООЦОО, ЛОЖИСТИКИЙН ХЭЛТЭС</p> <p>АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН..... Р.БАТБОЛД</p>		

ДЭНЧИН БАЙРШУУЛАХ ГҮЙЛГЭЭНИЙ УТГА

1. Арилжаанд оролцогчийн арилжааны дансны дугаар (Биржээс олгосон 10 оронтой дугаар)
2. Арилжаанд оролцогчийн регистрийн дугаар (хувь хүн бол өөрийн, компани бол татвар төлөгчийн дугаар)
3. Дэнчингийн төрөл (баталгаат дэнчин, анхдагч дэнчин, эсвэл хүргэлтийн дэнчин)

Жишээ нь:

0001000001 УС69010101 БАТАЛГААТ ДЭНЧИН
0001000001 УС69010101 АНХДАГЧ ДЭНЧИН
0001000001 УС69010101 ХҮРГЭЛТИЙН ДЭНЧИН

БАРЬЦАА БАЙРШУУЛАХ ГҮЙЛГЭЭНИЙ УТГА

1. Арилжаанд оролцогчийн арилжааны дансны дугаар (Биржээс олгосон 10 оронтой дугаар)
2. Арилжаанд оролцогчийн регистрийн дугаар (хувь хүн бол өөрийн, компани бол татвар төлөгчийн дугаар)
3. “Барьцаа”

Жишээ нь:

0001999999 УС69010101 БАРЬЦАА

ТӨЛБӨР БАЙРШУУЛАХ ГҮЙЛГЭЭНИЙ УТГА

1. Гэрээнд заасан хэлцлийн дугаар
2. Арилжаанд оролцогчийн арилжааны дансны дугаар (Биржээс олгосон 10 оронтой дугаар)
3. Арилжаанд оролцогчийн регистрийн дугаар (хувь хүн бол өөрийн, компани бол татвар төлөгчийн дугаар)

Жишээ нь:

000001 0001000001 УС69010101

ДЭНЧИНГИЙН МӨНГӨ БУЦААХ ХҮСЭЛТ

Огноо:

Хэнд: Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэс	Арилжаанд оролцогчийн дансны дугаар:	Буцаан шилжүүлэх дэнчингийн төрөл:
Дэнчингийн дүн, тоогоор:	Дэнчингийн дүн, бичгээр:	
Дэнчин хүлээн авах дансны мэдээлэл	Банкны нэр:	Дансны дугаар: Данс эзэмшигчийн нэр:
ХАРИЛЦАГЧИЙН ГАРЫН ҮСЭГ, ТАМГА		ГИШҮҮН ОРОЛЦОГЧИЙН ГАРЫН ҮСЭГ, ТАМГА
_____		_____

БАРЬЦАА ХӨРӨНГӨ БУЦААХ ХҮСЭЛТ

Огноо:

Хэнд: Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэс	Арилжаанд оролцогчийн дансны дугаар:	Буцаан шилжүүлэх дэнчингийн төрөл:
Барьцааны дүн, тоогоор:	Барьцааны дүн, бичгээр:	
Хүлээн авах дансны мэдээлэл	Банкны нэр:	Дансны дугаар: Данс эзэмшигчийн нэр:
ХАРИЛЦАГЧИЙН ГАРЫН ҮСЭГ, ТАМГА		ГИШҮҮН ОРОЛЦОГЧИЙН ГАРЫН ҮСЭГ, ТАМГА
_____		_____

Бараа хүлээлцсэн баримт

Хөдөө аж ахуйн биржийн 201_ оны ___ сарын ___ өдрийн арилжааны _____ дугаартай хэлцэл, түүнийг үндэслэн байгуулсан худалдах, худалдан авах гэрээний дагуу дараах бараа, түүхий эдийг хүлээлцэв.

1	Хүлээлцсэн огноо	
2	Хүлээлцсэн газар	
3	Бараа, түүхий эдийн код	
4	Бараа, түүхий эдийн гарал, үүсэл /аймаг, сум/	
5	Гэрээнд заасан бараа, түүхий эдийн хэмжээ /кг/	
6	Бараа, түүхий эдийн хүлээлцсэн хэмжээ /кг/	
7	Жингийн зөрүү /кг/	
8	Гэрээний нийт үнэ /төгрөг/	

	Хүлээлгэн өгсөн	Хүлээн авсан
Арилжааны дансны дугаар		
Овог, нэр / Байгууллагын нэр		
Регистрийн дугаар		
Утас		

Гарын үсэг

Гарын үсэг

Брокерын тамга

Брокерын тамга

ЗУУЧЛАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭХЭМЖЛЭХ

Огноо:

Хэнд:	Арилжаанд оролцогчийн дансны дугаар:	
Нэхэмжлэх дүн, тоогоор:	Нэхэмжлэх дүн, бичгээр:	
Гэрээнд заасан хэлцлийн дугаар:	Хэлцэл хийгдсэн огноо:	Хэлцэл хийсэн өдрийн 17:00 цагаас өмнө шилжүүлнэ.
Төлбөр хүлээн авах данс:	ХААН Банк 5099 04 0055 Төрийн Банк 1060 0002 6114	
НЭХЭМЖЛЭГЧ: ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ТӨЛБӨР ТООЦОО, ЛОЖИСТИКИЙН ХЭЛТЭС АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Р.БАТБОЛД		

Жич: Шимтгэл шилжүүлэхдээ гүйлгээний утгад дараах мэдээллийг бичнэ үү.

Шимтгэл_ хэлцлийн дугаар_харилцагчийн дансны дугаар. /Жишээ нь : Шимтгэл, 00100, 0041000001/